

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 06 дугаар сарын 29-ний өдөр

№ 26/33

Улаанбаатар хот

Чанаргүй болон муу активыг зээлийн эрсдэлийн сангаас хорогдуулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 68 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.21.4 дэх заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.23 дахь заалт болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2026 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компаниас гаргасан саналыг үндэслэн энэхүү тогтоолын Хавсралт №1-т заасан хэмжээ бүхий чанаргүй болон муу активыг, тэдгээрт тооцогдсон төлөгдөөгүй шимтгэл болон хүүгийн авлагын төлбөрийн хамт Зээлийн эрсдэлийн сангаас хорогдуулах, түүнтэй холбоотой холбогдох нягтлан бодох бүртгэлийн гүйлгээг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болгон хийх эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
2. Зээлийн эрсдэлийн сангаас чанаргүй болон муу активыг хорогдуулах ажиллагааг холбогдох хууль, тогтоомж болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын шаардлагад нийцүүлэн гүйцэтгэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.
3. Зээлийн эрсдэлийн сангаас чанаргүй болон муу активыг хорогдуулах ажиллагааны гүйцэтгэлийг Компанийн ТУЗ-д эргэн тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.

